

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:Дотуур байр.....

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1	Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан Баталгаат лабораторт шинжлүүлсэн эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүнээ нийлүүлэх ба тендерийн материалд тухайн хугацаанд дахь эрүүл ахуйн бичиг ирүүлнэ. Мах нь өөрийн өвөрмөц өнгөө хадгалсан .махны тод улаан өнгөтэй.цусны толбогүй үнэрийн өөрчлөлтгүй, бүрэн бүтэн ясны өөрчлөлтгүй гадаргуу цэвэр хуурай.загсаалтын хальстай .өөх нь цагаан шаргал.хатуу бүтэн ястай махыг нийлүүлнэ.Сар бүр гарал үүслийн гэрчилгээ,мал эмнэлэг,ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна. Зориулалтын зорь хөргөгчтэй байх Зориулалтын машинаар тээвэрлэдэг байх.		
2	Нийлүүлэгдэх төмс , хүнсний ногоо нь орон нутагт тариалагдсан стандартын шаардлага хангасан байна. - Төмс хүнсний ногоо нь хорхойд идэгдээгүй байх. Дагалдах бичиг баримтад тээвэрлэгч жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. - Лабораторын шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна. Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй соёологдоогүй хайрагдаагүй гадны		

	<p>үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.</p> <p>- Гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх, стандартын шаардлага хангасан байна</p> <p>- Байцаа нь бүтэн, цэвэр, нягт хумилттай, гадны амт, үнэргүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан.</p> <p>- Хүнсний ногоо нь цэвэр хэлбэр дүрсээ алдаагүй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч муудаагүй, ялзраагүй, гадны амт үнэргүй, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй байна.</p> <p>-Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.</p>		
3	<p>Стандартын шаардлага хангасан хүнсний эрүүл ахуй аюулгүй байдлын шинжилгээнд хамруулсан, механик хольцгүй, ямар нэгэн гаж амт, шороогүй байх, зориулалтын сав баглаа боодолтой гадны гэмтэл нөлөөллөөс хамгаалагдсан байх.Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх. Лабораторын шинжилгээний бичигтэй байна. Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй хөгцөрч муудаагүй байна. Чийг алдаагүй шинэ байна сүү сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна. Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ шингэн болон хөлдөөсөн байна. Тээвэрлэлтийн горимыг баримтлана. Хэт исгэлэн гашуун, ахарсан хөгцөрсөн биш байна. Гуриланд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.Гоймон нь гадны хольцгүй,хэрчилт жигд хэлбэр дүрсээ алдаагүй,гүйцэд чанахад хэлбэр дүрсээ алдахгүй , усанд уусч хоорондоо наалдахгүй,хүчиллэг чийг хүнд металлын хэмжээ зөвшөөрөгдөх эмгэг төрөгч нян илрээгүй байна. Цагаан будаа нь харлаж цоохортоогүй, хөгцний амт үнэргүй,хортон мэрэгч шавьж</p>		

<p>тэдгээрийн өт авгалдай, ялгадасаар бохирлогдоогүй байна. Том ширхэгтэй,цагаан будааны тоос,буталсан үрийн хэсэггүй байна. Өнгө нь хэт цагаан биш гэхдээ шарласан туяагүй байна. Хүнсний давс нь нунтаг цагаан өнгөтэй бөөгнөрч чийг аваагүй хатуураагүй байна. Элсэн чихэр нь стандартын шаардлагыг хангасан байна. Чийг бөөгнөрч хатуураагүй харлаагүй байна, Ургамлын тос шаргал өнгөтэй нэгэн төрлийн бие бүтэцтэй,булингар тунадас үүсээгүй хөлдөөгүй байна.Жимс жимсгэнэ нь хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй,гүйцэт боловсорсон зөөлөн эд нь нягт хатуу байдалтай,зөв хэлбэр дүрстэй,хортон шавьж мэрэгч, хачиг,авгалдай илрээгүй,хөгцөрч муудаагүй,ялзраагүй гадны амт үнэргүй,хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй ургамлын хорио цээрийн шаардлага хангасан гарал үүслийн гэрчилгээ шинжилгээний дүгнэлттэй байна.</p>		
--	--	--